

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар: 07

Улаанбаатар хот

Компанийн зохион байгуулалтын бүтэц,  
орон тооны хязгаар батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод (журам) хэм хэмжээ”-ний 2.8.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төрийн өмчийн оролцоотой нээлттэй компаниас бусад этгээд дэд захиралтай байхыг хориглосонтой холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн зохион байгуулалтын бүтцийг 1 дүгээр, орон тооны хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан компанийн хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолыг 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА





З.ЭНХБОЛД

“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар тогтоолын 1 дүгээр ХАВСРАЛТ



### “ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ





“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөгч удирдах зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар тогтоолын 2 дугаар ХАВСРАЛТ

**“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН  
ОРОН ТООНЫ ХЯЗГААР**

Д/д	Албан тушаалын нэр	Орон тоо
1.	Гүйцэтгэх захирал	1
<b>Андеррайтингийн газар</b>		
2.	Андеррайтингийн газрын захирал	1
3.	Удирдлагын мэдээллийн системийн мэргэжилтэн	1
4.	Ахлах андеррайтер	2
5.	Андеррайтер	7
<b>Бизнес хөгжил, төслийн газар</b>		
6.	Бизнес хөгжил, төслийн газрын захирал	1
7.	Давхар даатгалын ахлах менежер	1
8.	Төслийн ахлах менежер	1
9.	Төслийн менежер	1
10.	Шинэ бүтээгдэхүүн хариуцсан ажилтан	2
11.	Давхар даатгалын менежер	2
12.	Маркетингийн менежер	1
<b>Комплаенс, нөхөн төлбөрийн газар</b>		
13.	Комплаенс, нөхөн төлбөрийн газрын захирал	1
14.	Ерөнхий хуульч	1
15.	Хуульч	1
16.	Нөхөн төлбөрийн менежер	2
<b>Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар</b>		
17.	Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газрын захирал	1
18.	Ахлах актуарч	1
19.	Эрсдэлийн ахлах шинжээч	1
20.	Актуарч	1
21.	Хөрөнгө оруулалтын шинжээч	2
<b>Захиргаа, удирдлагын газар</b>		
22.	Захиргаа, удирдлагын газрын захирал	1
23.	Үнэт цаасны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
24.	Мэдээлэл технологийн ажилтан	1
25.	Хүний нөөцийн ажилтан	1
26.	Архив, бичиг хэргийн ажилтан	1
27.	Аж ахуй хариуцсан ажилтан	1
28.	Жолооч	2
<b>Санхүүгийн алба</b>		
29.	Ерөнхий нягтлан бодогч бөгөөд Санхүүгийн албаны дарга	1
30.	Ахлах нягтлан бодогч	1
31.	Нягтлан бодогч	1
32.	Худалдан авалт хариуцсан ажилтан	1
<b>Нийт орон тоо</b>		<b>44</b>